



УЛААНБААТАР ХОТЫН
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН
ТУШААЛ

2016 оны 05 сарын 06 өдөр

Дугаар А/66


Улаанбаатар хот

Тохижилтын ажлын задаргаа баталж,
гүйцэтгэгч сонгон шалгаруулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.4 дэх заалт, Нийслэлийн Засаг даргын "Эрх шилжүүлэх тухай" 2016 оны А/65 дугаар захирамж, Нийслэлийн засаг даргын 2014 оны А/279 дүгээр захирамжаар батлагдсан "Захирамжлалын баримт бичиг боловсруулах, хянах, мэдээлэх журам"-ын 2 дугаар хэсгийн 2.4.1, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны дүрмийн 1 дүгээр хэсгийн 1.3, 2 дугаар хэсгийн 2.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Засаг даргын 2016 оны "Эрх шилжүүлэх тухай" А/65 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралтын дагуу Нийслэлийн төсвийн хөрөнгөөр 2016 онд санхүүжүүлэх тохижилтын ажлын жагсаалтыг баталсугай.

2. Дээрх хавсралтаар батлагдсан ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, зөвлөмж хүргүүлэн ажиллахыг Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2016 оны А/15 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар байгуулагдсан Үнэлгээний хороо /Г.Батбаяр/-нд үүрэг болгосугай.



Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн
2016 оны 05 дугаар сарын 06.-ны өдрийн
А/66... дугаар тушаалын хавсралт

ТОХИЖИЛТЫН АЖЛЫН ЗАДАРГАА

№	Хийгдэх ажлын төрөл	Төсөв /сая.төг/
Чингэлтэй дүүрэгт хийгдэх тохижилтын ажлын нэр, байршил		
1	ЧД-ийн 16-р хороо согоотын 56-р гудамж, 12-р хороо Булгийн 18-р гудамжинд сагсан бөмбөгийн талбай, ахмадын амралтын орчинг бүрдүүлэх тохижилтын ажил	36.0
2	ЧД-ийн 16-р хороо согоотын 52-р гудамжны 585 худгийн актлагдсан барилгыг буулгаж шинээр худаг барих ажил	48.8
3	Чингэлтэй дүүргийн 12-р хорооны Булгийн 19-р гудамжны явган зам, гэрэлтүүлгийн ажил	76.0
4	Чингэлтэй дүүргийн 16-р хорооны согоотын-37 явган зам, гэрэлтүүлгийн ажил	60.0
5	Чингэлтэй дүүргийн 16-р хорооны согоотын-37 жишиг гудамжны тохижилтын ажил	78.7
6	ЧД-ийн 12,16-р хороодын 2 байршилд хог хаягдлыг цуглуулах нэгдсэн хогийн цэгийг шинээр байгуулах, зориулалтын бүрэн тоноглогдсон авто машин худалдан авах ажил	30.0
7	ЧД-ийн 16-р хороо, согоотын 59а гудамжинд зөөврийн худаг шинээр барих ажил	43.0
8	ЧД-ийн 16-р хорооны 139-р бага сургууль цэцэрлэгийн цогцолбор барилгын хойд талын согоотын 64-р гудамжинд явган хүний зам талбайг сайжруулах тохижилтын ажил	15.0
9	ЧД-ийн 16-р хороонд Согоотын 37-р гудамжинд "Био жорлон угсарч суурилуулах" ажил	10.5
Гудамжинд явган хүн, усны тэрэгний зам шинээр хийх		
10	16-р хороо 80-р гудамж 584 дугаар худагтай гудамж 250 м урт, 1 м өргөн зам	12.2
11	16-р хороо 79-р гудамж 583 худагтай гудамж 200 м урт, 1 м өргөн зам	11.5
12	16-р хороо 52-р гудамж 585 худагтай гудамж 100 м урт, 1 м өргөн зам	7.8
13	12-р хороо 18-р гудамж 158 худагтай гудамж 200 м урт, 1 м өргөн зам	10.3
14	12-р хороо 13-р гудамж 159 худагтай гудамж 100 м урт, 1 м өргөн зам	7.7
15	12-р хороо 13-р гудамж 600 худагтай гудамж 150 м урт, 1 м өргөн зам	9.5
Нийт		457
Сонгинохайрхан дүүрэгт хийгдэх тохижилтын ажлын нэр, байршил		
16	Сонгинохайрхан дүүргийн Үйлдвэрчний эвлэлийн гудамжны тохижилт	658.8
17	Сонгинохайрхан дүүргийн 18-р хороо 12-р сургуулийн гадна биеийн тамирын талбайн тохижилтын ажил	200.0
Нийт		858.8
Баянзүрх дүүрэгт хийгдэх тохижилтын ажлын нэр, байршил		
18	Баянзүрх дүүргийн 8 дугаар хорооны нутаг дэвсгэрт хүүхдийн тоглоомын талбай байгуулах ажил	50.0
19	Баянзүрх дүүргийн 11 дүгээр хорооны 6-р хэсэгт хүүхдийн тоглоомын талбай байгуулах	50.0
Нийт		100.0
Нийт дүн		1415.8